

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	2
1.2. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо	3
1.1 Ашиглалтын системийн сонголт	4
1.3. Уурхайн жилийн хүчин чадал ба ашиглалтын хугацаа	4
1.4. Уурхайн ажиллах горим	5
1.5. Ил уурхайн календарьчилсан төлөвлөгөө	5
1.2 Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмж	6
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	7
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	12
1.6. Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ	12
1.3 Төслийн гол сөрөг нөлөөллийг үнэлэх	16
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
1.4 Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	20
1.5 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	21
1.6 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	25
1.7 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .	26
1.8 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	27
1.9 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	27
1.10 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	28
1.11 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	30
1.12 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	31
1.13 Тухайн жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	33
1.14 Тухайн жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.	34
БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ	
36	

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

ТӨСЛИЙН НЭР:		Өргөний хайлуур жоншны бүлэг ордын 9-р бүсэд орших хүдрийн биетийг ил уурхайн аргаар ашиглах төсөл	
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН НЭР: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ: РЕГИСТРИЙН ДУГААР:		“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ 9013001062 2550466	
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ:		Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 22-р хороо, өөрийн байр Харилцах утас: 11-458072	
АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:		MV-012884 /35.5a/	
ТӨСЛИЙН БАЙРШИЛ:		Дорноговь аймаг Өргөн сум	
Ашигт малтмалын төрөл		жонш	
Орд ашиглалтын хугацаа		24 жил	
№	Үзүүлэлтүүд	Нэгж	Утга
1. Геологи, нөөц			
1	Нөөц хүлээн авах тухай ЭБМЗ-ийн дүгнэлт		ХХ-09-01
2	Нөөц бүртгэх тухай АМГ-ын даргын тушаал		Н/63
3	Нийт геологийн нөөц (B+C)	мян.тн	4,680.62
4	Ил уурхайн хүрэн дэх нөөц	мян.тн	3,356.95
5	Хаягдлын хэмжээ	%	8.12
6	Бохирдлын хэмжээ	%	14.53
7	Үйлдвэрлэлийн нөөц	мян.тн	3,571.22
2. Уурхай, олборлолт			
1	Уурхайн жилийн хүчин чадал	мян.тн	150 мян.тн
2	Уурхайн нийт хөрс хуулалт	сая.м ³	13.3
3	Хөрс хуулалтын дундаж коэффициент	м ³ /тн	3.73
4	Ашиглалтын систем	-	Авто тээвэр, галаал
5	Ажиллагсдын тоо	ш	110
3. Дэд бүтэц			
1	Цахилгааны эх үүсвэр	-	Төвийн эрчим хүчнээс
2	Цахилгааны жилийн хэрэглээ	мян.кВт/ж	5,622.03
3	Жилийн усны хэрэглээ	м ³	13,477
4. Эдийн засаг			
1	Төслийн нийт хөрөнгө оруулалт		11.11
2	Ашиглалтын нийт зардал		167.95
3	Борлуулалтын нийт орлого		195.67
4	Татварын дараах цэвэр ашиг	тэрбум ₮	24.94
5	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал		31.55
6	Инээлдүйн мөнгөний өнөөгийн үнэ цэнэ NPV		8.26
7	Өгөөжийн дотоод норм, IRR%	%	25
8	Хөрөнгө оруулалт нөхөх хугацаа	жил	3.53
9	Улс орон нутгийн төсөвт оруулах татвар,	тэрбум ₮	26.77
10	Татвар төлбөрүүдийн борлуулалтын орлогод эзлэх хувь	%	14


MV-012884 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл нь Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт Улаанбаатар хотоос зүүн урагш 507 км, Дорноговь аймгийн төв Сайншанд хотоос

зүүн урагш 60 км, Өргөн сумын төвөөс баруун урагш 2 км, Улсын хилээс баруун хойд зүгт 150 км-т оршино.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл нь Монгол орны 1:100 000-ны масштабтай байр зүйн зургийн L-49-114 дугаар номенклатур бүхий хавтгайд “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын эзэмшилд 35.5 га талбайг хамран оршино.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбицлууд

№	Эргэлтийн цэгийн өргөрөг			Эргэлтийн цэгийн уртраг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
1	44	42	24.811	110	44	42.896
2	44	42	20.884	110	44	40.437
3	44	42	20.952	110	44	49.584
4	44	42	1.685	110	44	49.693
5	44	42	1.603	110	44	25.153
6	44	42	21.09	110	44	24.947
7	44	42	20.939	110	44	29.135
8	44	42	24.743	110	44	29.067



Зураг 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байршлын тойм зураг

1.2. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НӨӨЦИЙН ТООЦОО

Өргөний хайлуур жоншны бүлэг ордын 9-р хүдрийн бүсийн нөөцийг ЭБМЗ-ийн 2024 оны 09-р сарын 20-ны өдрийн н/63 тоот дүгнэлтээр ордын хэмжээнд бодитой (В) зэрэглэлээр 1,483.24 мян.тн хүдэр дэх 41.67%-ийн агуулгатай 618 мян.тн эрдэс, боломжтой (С) зэрэглэлээр 3,197.37 мян.тн хүдэр дэх 40.47%-ийн агуулгатай 1,294.01 мян.тн эрдэс нийт бодитой (В) болон боломжтой (С) зэрэглэлээр ордын нөөцийг 4,680.62 мян.тн хүдэрт 40.85%-ийн агуулгатай 1,912.06 мян.тн эрдсийн нөөцийг улсын нэгдсэн санд бүртгүүлсэн.

Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаал буюу “АШИГТ МАЛТМАЛЫН БАЯЛАГ, ОРДЫН НӨӨЦИЙН АНГИЛАЛ, ЗААВАР”-ын дагуу ордыг бодитой (В) болон боломжтой (С) зэрэглэлийн нөөцөд тулгуурлан ТЭЗҮ-ийг боловсруулсан байна.

Үйлдвэрлэлийн нөөцийн нэгдсэн тооцоогоор 3,571.22 мян.тн хүдэрт 35.35%-ийн агуулгатай 1,262.49 мян.тн эрдэс олборлох тооцоо гарсан бол төслийн нийт хугацаанд 13.3 сая.м3 хөрс, ордын хэмжээнд хөрс хуулалтын дундаж коэффициент 3.73 м3/тн байна.

1.1 АШИГЛАЛТЫН СИСТЕМИЙН СОНГОЛТ

Ордын уул техникийн нөхцөл, хүдрийн биетийн хэлбэр ба байршил, хөрс хуулалтын хэмжээ зэргийг үндэслэж ордыг ил уурхайн аргаар, авто тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглах төслийг боловсруулсан. 9-р хүдрийн бүс нь “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ын дагуу 4-р бүлэг буюу ордын оновчтой хүрээ хязгаарыг бодитой (В) зэрэглэлийн нөөц болон боломжтой (С) зэрэглэлийн нөөцийн хүрээнд тодорхойлсон.

Өргөний хайлуур жоншны бүлэг ордын 9-р хүдрийн бүсийн биетийг ашиглах эхний үе шат: Ордын эхний үе шатанд ил уурхайн оновчтой хүрээ хязгаарын дагуу ил уурхайн үндсэн параметрийн дагуу ил уурхайг загварчилж 875 м-ийн түвшин хүртэл гүнзгийрч нийт 3,571.22 мян.тн хүдэр дэх 35.35%-ийн агуулгатай 1,262.49 мян.тн эрдэс олборлохоор төсөл боловсруулсан. Цаашид ордын үлдэгдэл нөөц болох 1,323.67 мян.тн хүдэрт агуулагдах 40.62%-ийн агуулгатай 537.67 мян.тн эрдсийг далд уурхайн аргаар ашиглах боломжийн судалгааг боловсруулахыг зөвлөмж болгож байна.

Хүснэгт 2. Ил уурхайн ашиглалтын технологийн схем

Технологи	Үндсэн ажил		Технологийн процессууд
Авто тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын технологи	1.	Хөрс хуулалт	ӨТА Ухаж ачих Тээвэрлэх Овоолох
	2.	Хүдэр олборлолт	ӨТА Ухаж ачих Тээвэрлэх Овоолох

1.3. УУРХАЙН ЖИЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ БА АШИГЛАЛТЫН ХУГАЦАА

Өргөний хайлуур жоншны бүлэг ордын 9-р хүдрийн бүсийн биетийг ашиглах ил уурхайн хүчин чадлыг захиалагч талын ажлын даалгаврын дагуу жилд 150 мян.тн хүдэр олборлохоор ТЭЗҮ-д тусгаж тооцлоо. Ил уурхайн эдийн засгийн үр ашигтай нөөц, үйлдвэрлэлийн нөөцийн хэмжээнд тулгуурлаж жилд 150 мян.тн хүчин чадлаар тус ордыг ашиглахад төсөл үргэлжлэх хугацааг 24 жил ашиглахаар тооцсон.

Уурхайн ажиллах горимыг, уурхайн хүчин чадал болон “Монгол Улсын хөдөлмөрийн хууль”-д заасны дагуу жилд амрах баяр ёслолын хоног, цаг агаарын хүндрэлээс шалтгаалан ил уурхайн үйл ажиллагаа түр зогсож болзошгүй хугацаа, өвлийн улиралд ажиллахгүй хоногийг тооцон жилд ил уурхайн хөрс хуулалт, хүдэр олборлолтод нийт 290 хоног ажиллалан.

1.4. УУРХАЙН АЖИЛЛАХ ГОРИМ

Ил уурхайн ажилчид 14/14 хоногийн ээлжийн системээр ажиллах ба хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Уурхайн хөрс хуулалтыг хөрсний гадаад овоолгод 2-3 орчим км зайд байршуулахаар төлөвлөж тээврийн тооцоог хийж гүйцэтгэсэн. Уулын ажил нь цаг агаарын саатал, төлөвлөгдөөгүй техникийн засвар үйлчилгээ, сул зогсолтоос хамааран эхний жилд баяр ёслол, амралтын өдрүүд 12 хоног, цаг агаараас хамаарсан сул зогсолт 5, уурхайн жилд ажиллах бодит хоног 290 хоног тус тус ажиллахаар төлөвлөсөн.

Хүснэгт 3. Ил уурхайн ажлын горим

№	Уурхайн ажиллах горим	Нэгж	Утга
1	Жилийн календарь хоног	хоног	365
2	Төлөвлөгөөт сул зогсолт	хоног	28
3	Жилд ажиллах календарь хоног	хоног	337
4	Цаг агаарын хүндрэлийн сул зогсолт	хоног	5
5	Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний сул зогсолт	хоног	15
6	Баяр ёслол, амралтын өдөр	хоног	12
7	Тэсэлгээний сул зогсолт	хоног	15
8	Жилд ажиллах хоног	хоног	290
9	Хоногт ажиллах ээлжийн тоо	хоног	2
10	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
11	Ээлжийн цаг ашиглалтын коэффициент	-	0.85
12	Ээлжид ажиллах бодит хугацаа	цаг	10.2
13	Жилд ажиллах бодит хугацаа	цаг	5916

1.5. ИЛ УУРХАЙН КАЛЕНДАРЬЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ил уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөөг ордын уул геологийн нөхцөл, болон захиалагчийн ажлын даалгаврын дагуу жилд 150 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтай байхаар төлөвлөж уулын ажлын нэгдсэн тооцоог хийж гүйцэтгэсэн. Ордын хөрс хуулалтын дундаж коэффициент 3.73 м³/тн байна.

Хүснэгт 4. Календарчилсан төлөвлөлт

Ашиглалтын жил	Хөрс хуулалт, мян.м ³	Хүдэр олборлолт, мян.м ³	Хүдэр олборлолт, мян.тн	К _{хх} , м ³ /тн	CaF ₂ -н агуулга, %	Эрдсийн нөөц, мян.тн	Уулын цулын хэмжээ, тн
1-р жил	987.23	56.68	150.0	6.58	34.96	52.44	1,043.91
2-р жил	1,012.26	56.04	150.0	6.75	38.87	58.31	1,068.30
3-р жил	1,007.10	57.11	150.0	6.71	32.43	48.65	1,064.22
4-р жил	997.35	56.90	150.0	6.65	33.55	50.32	1,054.25
5-р жил	947.99	56.90	150.0	6.32	33.63	50.45	1,004.88
6-р жил	998.73	56.93	150.0	6.66	33.37	50.05	1,055.66
7-р жил	978.73	56.93	150.0	6.52	33.77	50.66	1,035.66
8-р жил	754.63	56.54	150.0	5.03	35.78	53.66	811.17
9-р жил	685.21	56.54	150.0	4.57	36.10	54.15	741.75
10-р жил	698.40	56.54	150.0	4.66	36.69	55.03	754.94
11-15-р жил	3,058.58	281.27	750.0	4.08	35.95	269.59	3,339.86
16-24-р жил	1,196.65	495.91	1,321.22	0.91	35.51	469.15	1,692.56
Нийт дүн	13,322.87	1,344.28	3,571.22	3.73	35.35	1,262.49	14,667.15

Овоолгын төлөвлөлт: Уурхайн ашиглалтын нийт хугацаанд уурхайн хөрсийг өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлж, автосамосвалаар тээвэрлэн хөрсний гадаад

овоолгод хураана. Уг процессын үр дүнд хөрс нь 20%-иар сийрэгжинэ. Хөрсний гадаад овоолгын байршлыг сонгохдоо тээврийн зай, гадаргын хаялбар, салхины чиглэл, хүдэргүйжүүлэлт зэргийг харгалзан үзэн овоолгын байршлыг сонголоо.

Хөрсний гадаад овоолгын төлөвлөлтийг 20 м-ийн өндөр ярус, 6 м-ийн аюулгүйн тавцан, 36 градусын налуутай байхаар төлөвлөхөд хөрсний овоолгын ерөнхий налуу нь 32 градустай байгаа нь харьцангуй тогтвортой байна. Ашиглалтын жилийн эцсийн байдлаар сийрэгжсэн байдлаар нийт 15.9 сая.м³ хөрс хураахаар төлөвлөсөн болно.

Шимт хөрс хуулалтын ажил: Төсөл хэрэгжих нийт хугацаанд нийт 515 мян.м² талбай эвдрэлд өртөх тооцоо гарсан бөгөөд MNS 5917:2008 стандартын дагуу шимт хөрсийг 25 см зузаантай хуулж нийт 128 мян.м³ шимт хөрсний овоолгыг 5 метрээс хэтрэхгүй байхаар тооцож уурхайн баруун талд байршуулахаар ТЭЗҮ-д тусгасан болно. Шимт хөрс хуулах ажилд CAT D8 маркийн 1 ш бульдозер ашиглахаар тооцоо гарсан. Шимт хөрсийг (MNS 5917:2008) стандартын дагуу хураана.

1.2 Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмж

Өргөний хайлуур жоншны бүлэг ордын 9-р хүдрийн бүсийн биетийг ил уурхайн аргаар ашиглах 24 жилийн хугацаанд нийт 14.6 сая.м³ уулын цул үүний 13.3 сая.м³ хөрс хуулж, 35.35%-ийн дундаж агуулгатай 3,571.22 мян.тн хүдэрт нийт 1,262.49 мян.тн эрдсийн нөөц олборлох уулын ажлын тооцоо, төлөвлөгөөг хийж тусгасан байна.

Хүснэгт 5. Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмж	Марк	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга	Тоо	Ажлын зориулалт
1	Өрмийн машин	Atlas ROC L6	Хошууны диаметр	мм	152	2	ӨГА
2	Экскаватор	Hyundai-450LC	Утгуурын багтаамж	м ³	4.3	1	Хөрс хуулалт Хүдэр
3	Автосамосвал	SDLG MT86	Техникийн даац	тн	57	3	Уулын цул
4	Бульдозер	CAT D8	Хусуурын урт	м	3.9	1	Уулын цул
5	Утгуурт ачигч	WA320 PZ6	Утгуурын багтаамж	м ³	3.2	1	Хүдрийн овоолго
6	Автогрейдер	GR2403	Хусуурын	м	4.3	1	Зам арчилгаа
7	Усны машин	Dong Feng 25тн	Усны савны багтаамж	м ³	18	1	Зам арчилгаа

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

№	Байгаль орчны бүрдэл	Товч тайлбар
1.	Физик нөхцөл газарзүйн	<p>Дорноговь аймгийн нутаг бүхэлдээ говийн бүсэд багтдаг боловч өмнөд хэсэг нь говь, хойд хэсэг нь говь, хээр хосолсон нутаг юм. Дорноговь аймаг нь Монголын зүүн өмнөд хэсгийн талархаг гадаргатай хэсэгт оршдог.</p> <p>Өргөн сумын нутаг нь далайн түвшнээс дээш дунджаар 806-1214 метр өндөржилтэй. Энд Түшлэгийн уул(1047.8 м), Авдрангийн уул, Сүүжийн улаан овоо, Тасранхайн уул(1088 м), Өргөн уул(1120.3 м), Хайрхан уул(1049 м), Ар сүүж уул, Бага тариач(988.3м), Давхар ухаа(890 м), Зараа уул(934 м), Оройн шандын уул, Хөтлийн баян овоо(1181 м), Харагчингийн уул (1113 м), Гурван овоот(1036м), Аргалын уул зэрэг уулуудтай. Богинын хяр, Цагаан цав, Хөтийн хяр, Хотгор морьтын хэц, Могойтын хэц, Их бор цав газруудтай, ба Хөх хошууны говь, Долоотын говь, Унагын говь, Гурван булангийн говь, Улаан усны говь зэрэг томоохон голуудтай. Өлзийтийн хөндий, Гялгарын хөдий, Наймангийн тал, Туулайтын тал зэрэг томоохон талууд байдаг байна.</p> <p>Өргөн сумын нутаг нь том гол мөрөн, нуур байхгүй, харин газар доорх усны их нөөцтэй ба Улаан худгийн тойром, Сэртэнгийн тойром, Сүмбэрийн тойром зэрэг тойрмуудтай ба Цагаан нуур, Их улаан нуур зэрэг нуурууд байдаг байна.</p>
2.	Давхарга зүй	<p>Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн болон дүүрэгт неопротерозойн Норовзээг формац, неопротерозойн Өргөн формац, доод кембрийн Төгрөг худгийн формацын хувирмал чулуулаг, хотгор, хөндийд доод цэрдийн Цагаанцав формацын бялхмал болон тунамал, дээд цэрдийн Баруун гоёот формацын шаварлаг хурдаснууд тархсан. Дээрх хурдас чулуулаг дээр хожуу дөрөвдөгч болон орчин үеийн хурдас тархсан байна.</p>
3.	Геоморфологи	<p>Дүүргийн геоморфологийн бүтцийн тухай Г.В.Николаев (1971), Монгол-Зөвлөлтийн геологийн хамтарсан экспедицийн бүтээл “Геоморфология МНР” (1982), БНМАУ-ын атлас зэрэг геоморфологийн судалгааны ажлын бүтээлүүдэд тодорхой тусгагдсан.</p> <p>Төв Азийн геоморфологийн их муж, Өмнөд болон Зүүн говийн дэдмужид хамаарагдана (БНМАУ-ын атлас). Газрын гадаргуугийн хэлбэр дүрс үүсэж, бүрэлдэн тогтоход геологийн гадаад дотоод олон хүчин зүйл нөлөөлөх ба ялангуяа тектоник хөдөлгөөн гол үүрэгтэй. Гадаргуугийн хэлбэр дүрсийн хоёр үндсэн төрөлд хамаарагдана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Тэгшрэлийн намхан уул, толгод - Уул хоорондын хонхор, хотгор ба хуримтлалын тэгш тал
4.	Геологийн тогтоц	<p>Дорноговь аймгийн Өргөн сум нь Монгол орны геологийн серийн ангиллаар Нүхэт давааны сер, Улаан уулын мужлалд хамаарна.</p> <p>Өргөний хайлуур жоншны бүлэг ордын 9-р хүдрийн бүс нь өргөний хүдрийн талбайн төв хэсэгт 0.4 км² талбайг эзлэн оршино. Энэ бүс нь 45°-ын налуу уналтай үелэн тогтсон гантигжсан шохойн чулууны дээр нь занар ба доор нь гипербазитаас тус тус тогтоно. 9-р хүдрийн бүс нь дээд буюу</p>

		“Үндсэн”, доод үе болох “Хил зааг” орчмын гэж нэрлэгдсэн хоёр хүдрийн хэвтэшинээс тогтоно.
5.	Тектоник	<p>Өргөний хайлуур жоншны бүлэг орд нь Г.Бадарч (2002 он) нарын 1:1000000-ын масштабтай тектоник мужлалын ангиллаар Нүхэт давааны арлан нумын арын бүсэд, О.Төмөртогоо (2003 он) нарын ангиллаар Өмнөд говийн сүпер террейны Хутаг уулын эх газрын идэвхгүй зах, Ж.Бямба (2009 он) ангиллаар плит дундын терриген-карбонат бүрдэлд хамаарч байна.</p> <p>9-р хүдрийн бүсийн тектоник</p> <p>9-р хүдрийн бүсийн хэмжээнд 5 тектоникийн блок ялгагдаг. Эдгээр нь өмнөд, төв, хойд, баруун урд, баруун гэж хуваадаг. Өмнөд блок нь: Зүүн өмнөд төв блокуудтай зүүн хойд зүгт 40-50° чиглэлтэй шарнир төрлийн шилжилт зөрөлт бүхий хагарлын бүсээр хязгаарлагдсан. Энэ хагарлын бүс нь карьерт илэрдэг мөн № 62, 322, 322а, 326-р цооногуудад огтлогдсон. Энэ бүс нь агуулагч чулуулаг болон хүдрээс тогтсон брекч юм. Барьцалдуулагч карбонат сидерит байдаг. Дээрх хагарлаас баруун хойд зүгт 80 м–ийн зайд зэрэгцээ хагарал оршино. Энэ хагарал нь төв блокийг хойд блокоос тусгаарлана. Энэ хагарал нь андезит порфирын дэл чулуулгаар дүүрэгдсэн. Дэлийн зузаан 15 м.</p>
6.	Цаг уур уур амьсгал	<p>Өргөн сумын дулаан, хүйтний горимыг авч үзэхэд жилийн дундаж агаарын температур +2.8...+6.3°C бөгөөд өвлийн улиралд -10.3...-14.7°C, хаврын улиралд -0.7...+9.0°C, зуны улиралд +17.4...+22.9°C, намрын улиралд +12.7...14.5°C–ийн хооронд хэлбэлзэнэ.</p> <p>Өргөн сумын сүүлийн 8 жилийн цаг уурын мэдээгээр жилд 28.4... 181.5 мм хур тунадас унах бөгөөд өвлийн улиралд 0.4...2.5 мм, хаврын улиралд 1.7...22.6 мм, зуны улиралд 3.8...30.5 мм, намрын улиралд 2,2...22.2 мм-ийн хооронд хэлбэлзэнэ.</p> <p>Жилийн нийлбэр хур тунадас дунджаар 86.9 мм унадаг байна. 2014 онд хамгийн их буюу 181.5 мм, харин 2020 онд хамгийн бага буюу 29.9 мм хур тунадас унасан байна.</p> <p>Судалгаанд хамрагдаж буй бүс нутагт салхины хурд жилд дунджаар 2.6 м/с байдаг. Судалгааны талбайн салхины хурдны хувьд үндсэн хамгийн их утга нь 5 сард 5.0 м/с, хоёрдугаар их утга нь 9 сард 3.3 м/с ажиглагдсан бол үндсэн хамгийн бага утга нь 2 сард 1.1 м/с, хоёрдугаар бага утга нь 12 сард дунджаар 1.4 м/с тохиодог байна.</p>
7.	Агаарын чанар	<p>Бид агаарын чанарын хэмжилтийн цэгийг ашиглалтын талбай доор салхин дээр болон салхин доод талд гэж 3 цэг сонгон хэмжилт хийсэн.</p> <p>Тухайн шинжилгээний дүнгээр агаарын бохирдол бага гарсан байна. Бидний судалгаа хийсэн тухайн үед ашиглалтын талбайд олборлолт болон ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй байсан. Иймд тухай шинжилгээг тухайн хэсгийн суурь үзүүлэлт гэж үзлээ.</p>
8.	Гадаргын ус	<p>Өргөн сумын нутаг дахь Хөх эргийн булаг, Сухайн булаг зэрэг говийн нэгэн томоохон ай савд байдаг ундарга нь татраагүй байгаа булгуудын нэг билээ. Их хөөвөр булгийн ус хлорид – гидрокарбонат –натрийн найрлагатай, 782.65 мг/л эрдэсжилтгүй, 1.56 мг-экв/л хатуулагтай, түүнийг мал, ан амьтан уудаг байна.</p>

		Төсөл хэрэгжих талбайн ойр орчимд байнгын урсалттай гол горхи байхгүй байна. Харин хур борооны усаар тэтгэгдэг жижиг тойром нуур байдаг байна.
9.	Газрын доорх ус	<p>Өргөний хайлуур жоншны ордын агуулж буй Баргын овооны өргөгдлийн Геологи Геоморфологийн онцлогтой уялдуулж ус агуулагч доорх комплексуудыг ялгана.</p> <ul style="list-style-type: none"> • Дөрөвдөгчийн ус агуулагч хурдас • Дээд цэрдийн агуулагч хурдас • Дээд юра – доод цэрдийн ус агуулагч хурдас • Ан цавын ус агуулагч хурдас • Хувирмал Ан цавын ус агуулагч хувирмал хурдас • Дөрөвдөгчийн ус агуулагч хурдас <p>Энэ насны хурдас нь өндөрлөгүүдийн хажуу бэл мөн хөндийд үүсэж тогтсон хурдас нь хайрга шавранцар бүхий хурдас байх боловч хайрга хайрганцар голлосон байдаг. Хурдасны зузаан их биш -10-15 м суналын дагуу шаварлаг хурдас голлох үед ус агууламж эрс буурдаг. Хөрсний ус нь гадаргаас 2-3 м ховор үед 4-5 м хүрнэ. Энд нэвтэрсэн худгуудын ундарга 0,01-0,04 л/сек Ус нь гидрокарбанот – натри кальцын төрөлд орно. Эрдэжилт их бус 1,0 г/л-ээс хэтрэхгүй Усны тэжээлийн эх үүсвэр нь агаарын хур тунадас уулын хажуугаас шүүрч гардагтай холбоотой.</p>
10.	Хөрсөн бүрхэвч	<p>Төслийн талбай түүний орчмын хөрсөн бүрхэвчийн төлөв байдлыг тодорхойлох хээрийн судалгааг 2023 оны 10 дугаар сарын 08-нд хийж гүйцэтгэсэн. Төслийн талбай нь Говийн их мужийн заримдаг цөлийн цайвар бор хөрсний дэд бүсийн Дорноговийн тойрогт хамрагдаж байна (“Хөрс-газарзүйн мужлалт”, 2009).</p> <p>Химийн үндсэн шинж-Хөрсний үржил шимт үе давхаргын ялзмагийн агууламжийн дундаж утга нь 0.64 % буюу бага, хөрсний урвалын орчны дундаж утга нь pH-8.38 буюу саармаг, 100 г хөрсөнд агуулагдах хөдөлгөөнд фосфорын дундаж утга нь 1.3 мг буюу бага, солилцох калигийн дундаж утга 45.0 мг буюу маш их, хөрсний цахилгаан дамжуулах шинж чанарын дундаж утга 0.101 EC2,5 D/m буюу давсархаг биш байна. Хөрсний химийн шинжилгээнээс үзэхэд үржил шимийн ерөнхий түвшин бага зэрэг, нөлөөлөлд бага зэрэг өртсөн төлөвтэй байна.</p> <p>Хүнд металлын шинж чанар-Хүнд металлын дээжийг SGS лабораторид өгч, 33 төрлийн хүнд металлыг шинжлүүлсэн бөгөөд шинжилгээний үр дүнг MNS 5850:2019 (Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ) стандарттай харьцуулахад хүнд металлын элементүүд давсан үзүүлэлт илрээгүй.</p>
11.	Ургамлан нөмрөг	<p>Төсөл хэрэгжих талбай засаг захиргааны харьяаллаар Дорноговь аймгийн Өргөн сумын нутаг 1-р баг ийн нутаг тэгш тал газрын цөлөрхөг хээрт оршино. Газрын гадаргуу далайн түвшнээс дээш ... м өргөгдсөн дундаж өндөртэй. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбай нь эвдрэлд өртсөн талбайн ихэнх хэсэг уурхайн карьер болон овоолгод дарагдсан байдалтай байна.</p> <p>“9-р хүдрийн биет”-ийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Л.Өлзийхутагийн ургамал газар зүйн ангиллаар Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог хамаарна.</p>

		Ургамалжилтын судалгааны дүнд 9 овог, 13 төрөл, 16 зүйлийн гуурст дээд ургамал бүртгэгдсэн.
12.	Амьтны аймаг	Төсөл хэрэгжих бүс нутаг нь амьтны газар зүйн тойргоор (А.Г.Банников, 1954) Хойд говийн тойрогт хамаарна. Төсөл хэрэгжих талбайн байршил нь байгалийн бүс, бүслүүрийн хувьд цөлөрхөг хээрийн бүсэд, амьтны газар зүйн тойргоор хойд говийн тойрогт хамаарах бол биологийн олон янз байдлын амьдрах орчны нөлөөллийн үнэлгээгээр бүрэн өөрчлөгдсөн хамаарч байна. Энд мэрэгчдээс шар чичүүл <i>Meriones meridianus</i> , монгол чичүүл <i>Meriones unguiculatus</i> , морин чичүүл <i>Rhombomys opimus</i> , зараа хэлбэртнээс дэлдэн зараа <i>Hemiechinus auritus</i> -ны сэг зэм, туулай хэлбэртнээс бор туулай <i>Lepus tolai</i> , туурайтнаас хулан <i>Equus hemionus</i> , туруутнаас хар сүүлт <i>Gazella subgutturosa</i> , махчдаас үнэг <i>Vulpes vulpes</i> , хярс- <i>Vulpes corsac</i> зэрэг нийт 8 зүйл амьтад, мөлхөгчдөөс 2 салбар баг, 5 овог, 7 төрөлд хамаарах 7 зүйлийн мөлхөгчид идээшин амьдарч байна. Харин шувуудаас хот суурин газар шүтэж амьдрах хэрээний болон бор шувууны овгийн төлөөлөл түгээмэл тохиолдох бол CITES II хавсралтад бүртгэгдсэн 6 зүйл махчин шувуу (начин шонхор, идлэг шонхор, шилийн сар, нөмрөг тас, хотны бүгээхэй, хээрийн бүргэд) байгаа бол Дэлхийн байгаль хамгаалах холбооны шалгуур үнэлгээгээр (IUCN) олон улсын хэмжээнд эмзэг хэмээн үнэлэгдсэн Идлэг шонхор, нөмрөг тас зэрэг 16 зүйл тохиолдоно.
13.	Нийгэм эдийн засаг	Ил уурхайн ажиллах горим нь жилд 290 хоног тасралтгүй олборлолтын ажил явуулан хоногт 2 ээлжээр ажиллана. Ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Нийт 110 хүнийг ажлын байраар хангаж ажиллана. Уурхайн ажиллагсдын орон тоог 110 хүнээр тооцож, ажиллагсдад олгох цалин хөлсний хэмжээг тогтоохдоо цаашид цалинг өсгөх чиглэлийг мөн бусад уурхайн цалингийн жишгийг баримтлан тусгасан. Ажилчдын сарын дундаж цалин 2312 мян.төг болж байна.
14.	Дэд бүтэц	Өргөн нэртэй хайлуур жоншны бүлэг орд нь газарзүйн байршлын хувьд нэн таатай буюу Дорноговь аймгийн Өргөн сумын төвөөс баруун урагш 2 км зайд байршилтай нь дэд бүтцийн хувьд том давуу талтай юм. Өргөн нэртэй хайлуур жоншны бүлэг ордын 9-р хүдрийн бүсийн биетийг ил уурхайн аргаар ашиглах, боловсруулах тухайн төслийн цахилгаан эрчим хүчний үүсгүүр нь Зүүн бүсийн эрчим хүчний системд 110 кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугамд холбогдсон Зүүн өмнөд бүсийн цахилгаан эрчим хүч түгээх сүлжээний станц юм. Төслийн гадаад цахилгаан хангамжийг Өргөн сумын төвөөс төслийн талбай хүртэлх 2 орчим км зайд 10 кВ-ын агаарын цахилгаан дамжуулах шугам татаж эрчим хүчээр хангахаар тусгасан болно. Нөөц цахилгаан эрчим хүчний үүсгүүрээр дизель цахилгаан үүсгүүрийг ашиглахаар төсөлд тусгасан. Засвар, техникийн үйлчилгээний ажилчдын бүтэц тоог хөдөлмөр зарцуулалт, ажилчдын жилийн цагийн фондоор, туслах ажилчдын тоог үйлдвэрлэлийн ажилчдын тооны хувиар, техникийн үйлчилгээний газрын ажиллагсдын бүтэц орон тоог гаргасан.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнд өртөх байгаль орчин, тухайлбал, газрын гадарга хэвлий, агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтын аймаг, иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг чиглэл бүрээр гаргаж тусгасан. Мөн тэдгээр гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эрчим, тархалт, хэмжээг тодорхойлж, тоон ба чанарын үнэлгээ өгсөн дүнгүүдийг тусгасан болно.

Энд “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын Дорноговь аймгийн Өргөн сумын нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй Өргөний хайлуур жоншны бүлэг ордын “9-р бүсэд орших хүдрийн биет”-ийг ил уурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийн үнэлгээг тодорхойлов.

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь анх 1973 онд Монгол-Оросын хамтарсан “Монголросцветмет” нэгдэл нэртэйгээр байгуулагдсан бөгөөд хайлуур жонш, үнэт металл болон бусад төрлийн ашигт малтмалын хайгуул, олборлолт, баяжуулалтыг амжилттай гүйцэтгэж байгаа төрийн өмчит үйлдвэрийн газар юм. Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь Өргөний хайлуур жоншны бүлэг ордын хүдрийн 9, 14, 8-р бүсийг хамардаг ашиглалтын MV-000164, MV-012884, MV-013440 тоот тусгай зөвшөөрлүүдийг эзэмшдэг байна.

Тухайн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хүрээнд 9-р хүдрийн бүс-1 нэртэй MV-012884 тоот тусгай зөвшөөрөл бүхий 35.5 га талбай хамаарна.

Дорноговь аймгийн Өргөн сумын нутаг дахь Өргөний бүлэг орд нь 10 км² талбайг хамарсан 15 хүдрийн бүсээс тогтсон. Өргөний хайлуур жоншны бүлэг ордын Төв, 9, 14-р бүсэд 1981-2014 он хүртэлх хугацаанд ил уурхайн аргаар олборлолтыг “Монголросцветмет” ТӨҮГ явуулж байсан бөгөөд 2014 оноос эхлэн ил уурхайн олборлолт түр зогссон. “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь 2023 онд MV-012884 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн 9-р хүдрийн бүсэд ашиглалтын хайгуулын ажил хийж гүйцэтгэн ЭБМЗ-ийн 2024 оны 7-р сарын 4-ний өдрийн ХХ-09-01 тоот дүгнэлтээр нөөцийг шинэчлэн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна. Тухайн нөөцийн хүрээнд ТЭЗҮ-ийг “Жеммери” ХХК боловсруулан батлуулсан байна.

1.6. Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын Өргөний хайлуур жоншны бүлэг ордын “9-р бүсэд орших хүдрийн биет”-ийг ил уурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, дүгнэлт, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм- эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, газар дээр нь ажилласан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн магадлан жагсаах арга, матрицын аргаар тодорхойлсон болно. Энэ үнэлгээг доорх алхмуудаар гүйцэтгэв. Үүнд:

- ✓ Байгаль орчны үнэлгээний өмнөх үе шатуудад тодорхойлсон төслийн байгаль орчин, нийгмийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийн цар хүрээ, эрчим, хугацаа, шинж чанарыг нарийвчлан тодорхойлж, тоон ба чанарын шинжилгээ хийх;
- ✓ Болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний (зохих аргачлалын дагуу хийгдсэн) мэдээлэлд буулган судалж, сөрөг нөлөөллийн тархалт, үр дагаврыг үнэлэх;
- ✓ Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд төсөл хэрэгжих болон төслийн нөлөөлөлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн өнөөгийн төлөв байдал, бохирдол, доройтлын түвшнийг тогтоох нэмэлт судалгаа, ажиглалт, хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэх зэрэг орно.

Тухайн төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээг хийхдээ “Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга” (Checklist)-ыг хэрэглэв. Энэ арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм.

Аливаа төслийг хэрэгжүүлэх үеийн үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн байгаль орчны төлөв байдал болон нийгэм, эдийн засагт хэрхэн нөлөөлөх, нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчимшил зэргийг тодорхойлохын тулд магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргыг өргөн хэрэглэдэг. Энэ аргаар тухайн төслийн болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг хийхдээ экспертүүдийн гаргасан үнэлэлт, дүгнэлтүүдийг магадлалын онолд тулгуурлан боловсруулах замаар гүйцэтгэв. Тус аргыг ашиглах үед экспертүүдийн гаргасан үнэлэлт, дүгнэлт оролтын мэдээ болох бөгөөд үр дүнд төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах нөлөөллийг тогтооно.

Болзошгүй нөлөөлөлд хамрагдах байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт, байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны өөрчлөлт, нийгэм-эдийн засаг болон бусад гэсэн 5 үндсэн бүлэгт багцлан хувааж, магадлан жагсаах аргаар судлав. Нөлөөллийг “сөрөг”=(х), “эерэг”=(+), “нөлөөлөлгүй”=(0) гэсэн 3 бүлэглэлээр үнэлж, эрчимжилтийг: “бага зэрэг”, “дунд зэрэг”, “хүчтэй” гэсэн 3 зэргээр тогтоож, хэлбэр, хугацаа, чиглэлээр нь үнэлсэн болно.

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ийн “9-р бүсэд орших хүдрийн биет хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төсөл”-ийн болзошгүй нөлөөллийн үнэлгээг магадлан жагсаах аргаар гүйцэтгэн доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 6. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах байдал

№	Байгаль орчны үзүүлэлтүүд	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны /0-3 жил/	Дунд хугацааны /4-9 жил/	Урт хугацааны /10-аас дээш жил/	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
Байгалийн экосистемийн өөрчлөлт												
1	Газрын доорх урсцын өөрчлөлт	х					х		х		х	
2	Гадаргын усны урсцын өөрчлөлт	0										
3	Ургамлын бүлгэмдэл, бүтцэд өөрчлөлт орох, талхлагдах	х					х	х			х	

№	Байгаль орчны үзүүлэлтүүд	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны /0-3 жил/	Дунд хугацааны /4-9 жил/	Урт хугацааны /10-аас дээш жил/	Буцаж нөлөөлөх	Будалгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
4	Хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэлд орох, дарагдах	x					x			x		
5	Геологийн тогтцын өөрчлөлт	x					x		x	x		
6	Ойр орчимд нутагладаг ан амьтдын амьдрах орон зай өөрчлөгдөх		x		x			x				x
7	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			x	x			x				x
Байгалийн нөөц, ашиглалт												
8	Газрын доорх нөөц баялаг	x					x		x	x		
9	Газрын доорх усны нөөц багасах	x			x				x		x	
10	Бэлчээр	x			x			x				x
11	Эрдэс түүхий эдийн нөөц	x					x					x
12	Эрчим хүчний нөөц			x	x				x			x
Байгаль орчны чанарын өөрчлөлт												
13	Газрын доорх усны чанарын өөрчлөлт		x				x	x			x	
14	Гадаргын усны чанарын өөрчлөлт		x				x	x				x
15	Агаарын бохирдол	x					x		x			x
16	Хөрсний бохирдол	x			x			x				x
17	Хорт бодис усаар дамжин хүн ам, ан амьтанд нөлөөлөх		x				x		x			x
18	Дуу чимээ, шуугианы нөлөө	x					x	x			x	
Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор												
19	Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	x					x		x		x	
20	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх		x				x		x			x
21	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	0										
22	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	0										
23	Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх	0										
Эдийн засаг, нийгмийн асуудал												
24	Орон нутгийн орлого нэмэгдэх	+					+		+		+	
25	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		+				+		+		+	
26	Ажлын байр нэмэгдэх	+					+		+			+
27	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+					+		+		+	
28	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x				x	x				x
Бусад нөлөөлөл												

№	Байгаль орчны үзүүлэлтүүд	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны /0-3 жил/	Дунд хугацааны /4-9 жил/	Урт хугацааны /10-аас дээш жил/	Буцаж нөлөөлөх	Будалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
29	Үйлдвэрийн барилга байгууламжийг барих үед орчны хөрсний эвдрэл, бохирдол гарах	х					х	х				х
30	Ахуйн болон үйлдвэрийн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс ба газрын доорх усыг бохирдуулах	х					х	х				х
32	Хүчтэй салхи, түймэр газар хөдлөл, аянга цахилгаан	х					х	х		х		
33	Дүн	19	7	2	10	-	32	14	12	5	9	14

Дээрх магадлан жагсаах аргаар нийт 6 бүлэгт хуваан 32 шалгуурыг тавьж анализ хийсэн болно. Ингэхэд уг төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарч болох байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл нь үйлдвэрийн технологийн онцлогоос хамаарч байгалийн экосистем, байгалийн нөөц, байгаль орчны чанарт сөрөг, харин улсын болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн асуудалд эерэг нөлөөтэй байгаа нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Иймд тэдгээрт задлан шинжилгээ хийж дараах дүгнэлт өгч болох юм. Үүнд:

Шууд ба шууд бус нөлөөлөл, түүний эрчим: нийт болзошгүй гэж үзсэн нөлөөллүүдийн 19 нь шууд нөлөөлөлд хамаарах бөгөөд үүний 3 нь эерэг нөлөөтэй байна. Энд болзошгүй нөлөөллийн ихэнхи нь шууд нөлөөлөлд хамаарч буй бөгөөд ил уурхайн олборлолт, уурхайд шүүрэн орох усыг шавхан зайлуулах, гадаад овоолго үүсгэх зэрэг нь геологийн тогтоц, газрын доорх усны урсац, нөөц, горим өөрчлөгдөхөд шуудаар нөлөөлнө. Харин уурхайн үйл ажиллагаа эхлэх үед орон нутгийн орлого нэмэгдэх, ажлын байр шинээр бий болох, ядуурлыг бууруулахад дэмжлэг болох шууд эерэг нөлөөлөл нь хүчтэйгээс дунд зэрэг нөлөөтэй байгаа нь хүснэгтээс харагдаж байна. Үйлдвэрийн болон уурхайчдын тосгон, бусад барилга байгууламжуудыг нэмэлтээр барих тохиолдолд хөрсний элэгдэл, эвдрэл гарах, түүнтэй уялдан орчинд тоос, хүнд машин механизмын яндангаас гарах утаа, хий зэрэг нь агаарын орчныг дунд зэрэг бохирдуулах нөхцөлтэй байна. Харин санамсар болгоомжгүйгээс нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис зэргийг алдаж асгасан тохиолдолд орчны хөрс бохирдуулах, хүн малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх магадлал ихтэй тул шууд, хүчтэй зэргийн эрчимтэй нөлөөлөлд хамааруулж үзсэн болно. Дунд хугацааны ийм хэлбэрийн нөлөөлөл нь усаар дамжин хүн ам, ан амьтанд нөлөөлөх, үйлдвэрийн барилга байгууламжийг барих үед орчны хөрсний бохирдол гарах, ахуйн болон үйлдвэрийн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс ба газрын доорх усыг бохирдуулах, хүчтэй салхи, түймэр, газар хөдлөл, аянга зэрэг байгалийн гамшгийн үзэгдлүүдтэй холбоотой сөрөг нөлөөлөл орж байна. Мөн ядуурлыг бууруулахад дэмжлэг болох эерэг нөлөөлөл мөн энд хамаарч байна.

Нөлөөллийн хугацаа: төслөөс үзүүлэх нөлөөллийн үргэлжлэх хугацааг 0-3 жил бол богино, 4-9 жил бол дунд, 10 ба түүнээс дээш жилээр байх тохиолдолд урт хугацааны гэж авч үзсэн болно. Тухайн төсөл нь 24 жил үргэлжлэхээр төлөвлөсөн тул урт хугацааны

нөлөөлөлд хамаарагдаж байна. Үйлдвэрийн ойр орчны ургамлан нөмрөгийн зүйлийн бүрдэл, биомассын хэвийн байдал алдагдаж доройтох, мөн хөрс эвдрэх, үйлдвэрийн технологид газрын доорх усны нөөцийг авч ашиглах тул түүний нөөц, урсцын горимд тодорхой хэмжээгээр өөрчлөлт гарах, ус ба хөрсний бохирдолт үүсэх зэрэг нь эргэж сэргэхдээ маш удаан хугацаа шаардагддаг онцлогтой тул урт хугацааны нөлөөлөлд хамаарагдаж байна.

Ил уурхайн нь өдрийн 2 ээлжээр жилд 290 хоног ажиллахаар төлөвлөсөн тул уулын ажлын үед дуу чимээ ихсэх, хөрс болон агаар тоосоор бохирдох, машин механизмуудын яндангаас агаарт хорт утаа хаягдах, хог хаягдлын цэгийг тогтмол ариутгаагүй ил задгай байлгаснаас эвгүй үнэр гарах, ялаа, шавж үржих зэрэг сөрөг нөлөөтэй ба эсрэгээрээ орон нутгийн төсөвт оруулах орлого татварын тодорхой хэмжээгээр нэмэгдэх түр хугацааны ажлын байр бий болох зэрэг эерэг нөлөөтөө байна. Утаа тоос шороогоор агаарын богино хугацаанд ч гэсэн бохирдуулахгүйн тулд дизель хөдөлгүүрийн янданд шүүлтүүр тавих, ухагдсан хөрс шороо, машин механизмд талхлагдсан орчны газрыг шаардлагатай үед услаж чийглэж байх, ахуйн хатуу, шингэн хог хаягдлын (нүх) цэгийг хлорамин зэрэг ариутгагч бодисоор тогтмол ариутгаж байх шаардлагатай

Буцаж нөлөөлөх: Үүнд химийн бодис, нефтийн бүтээгдэхүүн болон ахуйн бохирдлоор бохирдсон хөрс, гүний усыг бохирдуулах улмаар хүн, мал, амьтаны эрүүл мэндэд шууд ба шууд бусаар эргэж нөлөөлөх, ахуйн хаягдлыг тухай бүр устгаагүй болон ариутгаагүйгээс болж хаягдлын цэгт ялаа шавж үржиж тэр нь буцаж нөлөөлөх талтай. Мөн гал алдсаны улмаас хээрийн түймэр гарч ойр орчмын бусад объект болон ургамалд нөлөөлөх магадлалтай ба үүдэн гарах хохирол нь харьцангуй их байх магадлалтай юм.

Буцалтгүй нөлөөлөл: Энэ төрөлд тухайн сөрөг нөлөөлөл нь байгаль орчинд буцаж нөхөн сэргээх нөхцөл багатай болон сэргээгдэшгүйгээр нөлөөлөх нөлөөлөл хамаарагдах бөгөөд үүнд газрын доорх усны урсацын өөрчлөлт, хөрс, газрын элэгдэл эвдрэл, байгалийн үзэсгэлэнт төрх, ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх зэргийн сөрөг нөлөөллөөс гадна ихэнхи эерэг нөлөөллүүд хамаарч байна. Дээрх байдлаас үзэхэд уг ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн үргэлжлэх хугацаа дийлэнх нь дунд зэргийн хугацаагаар. эрчмийн хувьд 5 нөлөөлөл хүчтэй, 9 нь дунд үлдсэн 14 нь бага зэрэг байгаа нь нөхөн сэргээх, үүссэн сөрөг нөлөөг багасгах арилгах асуудлыг үйлдвэрийн үйл ажиллагааны үед мөрдөх байгаль хамгаалах болон нөхөн сэргээх төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан ажилтай нарийн уялдуулан хийж байх нь зайлшгүй нэн түрүүний асуудал болохыг дахин баталж байна.

1.3 Төслийн гол сөрөг нөлөөллийг үнэлэх

Дээр өгүүлсэн болзошгүй нөлөөллийн судалгааны үр дүнгээс төсөл хэрэгжих үеийн болон ашиглалтын үе шатанд хөрс, агаар, бэлчээр, газрын доорх ус зэрэгт ихээхэн нөлөөтэй болох нь харагдаж байна. Иймд эдгээр нь голлох нөлөөлөлд багтана. Сөрөг нөлөөллийг байгаль орчны үзүүлэлт тус бүрээр дэлгэрэнгүй авч үзлээ.

Хүснэгт 7. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөл

№	Экологийн бүрэлдэхүүн	Үүсэх сөрөг нөлөөлөл
1.	Агаарын чанар	<p>Өргөний хайлуур жоншны бүлэг ордын “9-р бүсэд орших хүдрийн биет”-ийг ил уурхайн аргаар ашиглах төслөөс газрын гадарга хэвлийд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний дунджаар 55.6 буюу дунд үлдэгдэл нөлөөлөл үзүүлэх ба гол нөлөөлөл нь ил уурхайн гадаад хөрсний овоолго, тээвэрлэлтээс үүсэх тоосжилт байна. Мөн дараах сөрөг нөлөөлөл үүснэ гэж үзлээ.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Ил уурхайн гадаад овоолго үүсгэх болон тээвэрлэлтээс хамгийн их тоосжилт үүснэ. Уурхай ажиллаж байх үед усалгаа хийж тоосжилтыг 70%-иар бууруулах боломжтой гэж үзлээ. ✓ Мөн ашиглагдаж буй хүнд даацын тээврийн хэрэгслүүдэд сайн чанарын түлш ашиглаж хийн бохирдлыг багасгах бүрэн боломжтой
2.	Газрын хэвлий, гадаргад	<p>Өргөний хайлуур жоншны бүлэг ордын “9-р бүсэд орших хүдрийн биет”-ийг ил уурхайн аргаар ашиглах төслөөс газрын гадарга хэвлийд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний дунджаар 51.66 буюу дунд үлдэгдэл нөлөөлөл үзүүлэх ба гол нөлөөлөл нь ил уурхайн олборлолтоос үүсэх карьер, гадаад хөрсний овоолго зэргээс үүсэх байна. Мөн дараах сөрөг нөлөөлөл үүснэ гэж үзлээ.</p> <ul style="list-style-type: none"> ✓ MV-012884 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд өнөөгийн байдлаар 21.64 га талбайд 65 м гүнтэй карьер үүссэн. Тухайн талбай буюу Өргөний хайлуур жоншны бүлэг ордын Төв, 9, 14-р бүсэд 1981-2014 он хүртэлх хугацаанд ил уурхайн аргаар олборлолтыг үйл ажиллагаа явуулж байсан ба 2014 оноос үйл ажиллагаа түр зогссон. Цаашид MV-012884 тоот ашиглалтын талбайд 24 жилийн хугацаатайгаар ил уурхайн аргаар олборлохоор төлөвлөсөн ба эхний 5 жилийн хугацаанд уурхайн карьер 3.254 га талбайгаар тэлж 24.89 га талбайд үүсэх ба карьерын амарсан хамгийн өргөн хэсэгтээ 560 м, урт нь 650 м хүрэх бол 95 м гүн болохоор байна. ✓ “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ газар нь Өргөний бүлэг ордод 3 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг ба MV-012884 тоот ашиглалтын талбайд ил уурхайн олборлолтын үйл ажиллагаа явагдаж, MV-013440 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд дгадаад овоолго үүсгэж ажиллахаар төлөвлөсөн. Өнөөгийн байдлаар 28.7 га талбайд хөрсний гадаад овоолго үүсэн цаашид 24.42 га талбайгаар тэлж байна. ТЭЗҮ-ний төлөвлөлтийн дагуу ашиглалтын талбайн хилээс гарч байна. ✓ Өргөний бүлэг ордод 9 ашиглалтын тусгай зөвшөөрөл 1 хайгуулын тусгай зөвшөөрөл байгаа ба иргэний эзэмших газар байхгүй. Мөн ашиглалтад өртөх талбай нь бусдын эзэмшил газартай давхцал үүсэхгүй байна. ✓ “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ газрын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 3 талбай нь үүсэх карьерын амсрын хүрээгээр олгогдсон тул уурхайн хотгон, засварын газар, тэсрэх материалын агуулах зэрэг барилга байгууламж баригдах газрууд зөвшөөрөлгүй байна. Иймд төлөвлөгөөт газруудыг сумын ерөнхий төлөвлөгөөнд тусгуулан зөвшөөрөл авах шаардлагатай.

№	Экологийн бүрэлдэхүүн	Үүсэх сөрөг нөлөөлөл
3.	Усан орчин	<p>Өргөний хайлуур жоншны бүлэг ордын “9-р бүсэд орших хүдрийн биет”-ийг ил уурхайн аргаар ашиглах төслөөс усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээний дунджаар 33.5 буюу дунд үлдэгдэл нөлөөлөл үзүүлэх ба гол нөлөөлөл нь уурхайн шүүрлийн усны шавхан зайлуулалт юм. Ашиглалтын талбайд ил уурхайн олборлолтын ажил явагдах ба баяжуулалтын ажил хийгдэхгүй. Иймд унд ахуйн хэрэглээ, зам талбайн тоосжилт дарах, ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар ус ашиглаж байна.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн хүрээнд ашиглах усны хэрэглээ бага ч уурхайнд шүүрэн орж ирэх усыг шавхалтын ажил хийгдэх тул газрын доорх усны нөөц сөрөг нөлөөтэй. ✓ Уурхайн шүүрлийн усыг хяналт төлөвлөлтгүйгээр шууд шавхах ✓ Төсөл нь хэрэгжих эхэлснээр нийт 110 хүн ажиллах ба ахуйн гаралтай бохир усыг шууд хөрсөнд шингээж хөрсөөр дамжин усан орчин бохирдох магадлалтай ✓ Унд ахуйн хэрэглээний усыг Өргөн сумын төв худгаас авч ашиглахаар төлөвлөсөн.Цаашид өөрийн эзэмшлийн гүний худаг гарган ашиглахаар төлөвлөсөн тул орон нутгаас холбогдох зөвшөөрлийг авч ажиллах. ✓ Уурхайн шүүрлийн усны тооцоог урьдчилсан байдлаар өмнөх мэдээ материал дээр үндэслэн гарсан бай цаашид ордын хэмжээд гидрогеологийн нарийвчилсан судалгаа хийлгэх шаардлагатай. ✓ Уурхайгаас шавхан зайлуулах усаар хөв цөөрөм байгуулах
4.	Хөрсөн бүрхэвч	<p>Өргөний хайлуур жоншны бүлэг ордын “9-р бүсэд орших хүдрийн биет”-ийг ил уурхайн аргаар ашиглах төслөөс хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээний дунджаар 40.2 буюу дунд үлдэгдэл нөлөөлөл үзүүлэх ба гол нөлөөлөл нь уурхайн шүүрлийн усны шавхан зайлуулалт юм. Ашиглалтын талбайд ил уурхайн олборлолтын ажил явагдах ба баяжуулалтын ажил хийгдэхгүй. Ил уурхайн 7 дах жил хүртэл шимт хөрс хуулалтын ажил хийгдэнэ цаашид шимт хөрс хуулахгүй байна. Мөн ил уурхайн амсар тэлэхгүй гүнзгийр ч байна.</p>
5.	Ургамлан нөмрөг	<p>Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд Монгол орны улаан ном” (2013)-ын ургамлын жагсаалтад орсон нэн ховор, ховор ургамал, “Монголын ургамлын улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл” (2012) -д Олон улсад судлагдаагүй, бүс нутгийн ховордлын зэрэглэл, улаан дансанд (Нямбаяр нар, 2012) бүртгэгдсэн ургамал тэмдэглэгдээгүй.</p> <p>Өргөний хайлуур жоншны бүлэг ордын “9-р бүсэд орших хүдрийн биет”-ийг ил уурхайн аргаар ашиглах төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээний дунджаар 53 буюу дунд үлдэгдэл нөлөөлөл үзүүлж байна.</p> <p>Төсөл хэрэгжих талбай нь 1981-2014 он хүртэлх ил уурхайн аргаар олборлолтод өртөж байсан ба 21.64 га талбайд карьер үүсэж ургамлан нөмрөг устан, 28.7 га талбайд гадаад овоолго үүсэж ургамлан нөмрөг дарагдсан байдалтай байна.</p> <ul style="list-style-type: none"> ✓ MV-012884 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн 35.5 га талбай бүхэлдээ нөлөөлөлд өртөж ургамлан нөмрөг өөрчлөгдсөн.

№	Экологийн бүрэлдэхүүн	Үүсэх сөрөг нөлөөлөл
		<ul style="list-style-type: none"> ✓ MV-013440 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд гадаад овоолго үүсэхээр төлөвлөсөн. Нийт талбай ургамлан нөмрөг устана. ✓ Уурхайн барилга байгууламжийн нөлөөгөөр 2.98 га талбай нөлөөлөлд өртөж ургамлан нөмрөг доройтон. ✓ Хүдрийн түр овоолгоос Өргөн өрөө хүртэл 3.2 км замыг засаж сайжруулах ба тухайн маршрутын дагуу ургамлан нөмөр устгах ба нөлөөллийн бүсийн ургамалан нөмрөг тоосжилтоос үүдэн доройтох магадлалтай. ✓ Ил уурхайн нь 24 жил үргэлжлэх ба БОННУ-ний 5 жилийн хугацаанд нөхөн сэргээх орон зай үүсэхгүй. Иймд нөхөн тухайн жилүүдэд ногоон байгууламж үүсгэх шимт хөрсийн овоолгыг ургамалжуулах ажлыг хийж гүйцэтгэх хэрэгтэй.
6.	Амьтны аймаг	<p>Дорноговь аймгийн Өргөн сум, төсөл хэрэгжих газар нутгийг чухал, хэвийн буюу байгалийн, өөрчлөгдсөн хэмээн үндсэн гурван хэв шинжид хуваасан. Үүнд: Чухал ангилалд УТХГ, хамгаалах шаардлагатай гэж тогтоосон газар нутгууд энэ ангилалд хамаарна. Хамгийн их нөлөөлөлд өртсөн газар буюу 5% нь Монгол улсын нөлөөллийн индексийн дагуу өөрчлөгдсөн гэсэн төрөлд хамаарах бөгөөд суурьшлын болон уул уурхай, дэд бүтцийн шууд ба шууд бус нөлөөлөлд өртсөн газар нутгууд хамаарна. Дээрх хоёроос бусад газар нутгууд хэвийн буюу байгалийн төрөлд орно.</p> <p>Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээний дунджаар 25.25 буюу бага үлдэгдэл нөлөөлөл үзүүлж байна. Төсөл хэрэгжих талбай нь 1981-2014 он хүртэлх ил уурхайн аргаар олборлолтод өртөж байсан мөн Замын үүд Улаанбаатар хотыг холбосон авто зам болон болон төмөр замтай ойр орших тул амьтад дайжсан байна.</p>
7.	Хог хаягдал	<p>Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээний дунджаар 22.25 буюу бага үлдэгдэл нөлөөлөл үзүүлж байна. Төслөөс онцгойлон анхаарах шаардлагатай химийн хог хаягдал гарахгүй ил уурхайн талбайд баяжуулах ажил хийгдэхгүй.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төсөлд нийт 15 тээврийн хэрэгсэл ашиглагдах ба ашиглалтаас гарах ашиглагдсан тос масло, аккумулятор, зэргийг аюултай хог хаягдалд оруулж үзсэн. Мөн гарах хэмжээг урьдчилан тооцоож тайланд туслаа. ✓ Төсөл хэрэгжсэнээр 110 хүнийг ажиллын байраар хангаж ажиллах ба гарах хог хаягдлыг урьдчилан тооцож тайланд тусгалаа. Ахуйн гаралтай хатуу хог хаягдал хоногт 33 кг, шингэн хог хаягдал 5.04 м³ урьдчилсан тооцоо гарсан. ✓ Төслийн олборлолтын үйл ажиллагаанаас анхаарах шаардлагатай химийн хортой хог хаягдал гарахгүй.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.4 Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг тогтмол хянах зорилготой. Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорино.

Үүнд:

- ✓ Уурхайн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа талбайн хэмжээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангах,
- ✓ БОННҮнэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх,
- ✓ Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хамаарал, хамрах хүрээг тодорхойлох,
- ✓ Уурхайн үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа баримтлан хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг тодорхойлох,
- ✓ Орон нутагтай байгаль хамгаалах, дүйцүүлэн хамгаалах ажилд хамтран ажиллах,
- ✓ Талуудын оролцоог хангах, ОХШХ-т олон нийтийн оролцоог хамруулах, тайлагнах тогтолцоог сайжруулах,

1.5 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Газар ашиглалт								
1	Ашиглалтын талбайгаас газар ашиглалт гарах. Зөвшөөрөлгүйгээр газар ашиглах	Барилга байгууламж баригдах газруудыг сумын ерөнхий төлөвлөгөөнд тусгуулан Өргөн сумын Засаг Даргаас газар ашиглах гэрээ болон гэрчилгээг гаргуулах.	Уурхайн кемп, засварын газар, тэсрэх материалын агуулах	га	-		Дотоод зардал тусгах	2026 ололборлолтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө.	Газрын тухай хууль
2		Ашиглалтын явцад гадаад овоолгын талбай тэлж ашиглалтын талбайгаас гарах магадлалтай тул овоолгын талбайд газар ашиглах зөвшөөрлийг Өргөн сумын Засаг Даргаас авах.	Гадаад овоолгын талбай	га	-		Дотоод зардал тусгах	2026 ололборлолтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө.	Газрын тухай хууль
3		Уурхайн хүдрийн түр овоолгоос Өргөн өртөө хүртэлх замын маршрутыг батлах	Гадаад тээврийн 3.3 км зам	км			-	2026 он Ажлыг эхлэх	Засгийн газрын 2018 оны 12-р сарын 12-ны өдрийн 379 дүгээр тогтоол /3.4, 3.5, 3.8-р зүйл заалтууд/
4		Уурхайн карьер, суваг шуудуу нь хүн, мал, амьтан унах осолдохоос сэргийлсэн	Ил уурхайн талбай	м	-			2026 он	Хөрс хамгаалах цөлжилтэй тэмцэх хууль

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
		хаалт хашлага хийх. Жил бүр засаж сайжруулж байх							
5		Ил уурхайн эргэн тойронд нь анхааруулах, хориглох санамж тэмдэг тэмдэглэгээг байршуулах.	Уурхайн бүсд	Ширхэг				2026 он Уурхайн олборлолтоос өмнө	
Агаарын чанар									
1	Уурхайд ашиглагдаж буй замаас тоос дэгдэж хүрээлэн буй орчинд тархах;	Уурхай дотор замыг тэмдэгжүүлэх. Ил уурхай уурхайн ам Авто зогсоол Шимт хөрсний овоолго Хоосон чулуулгийн овоолго Тээврийн зам дагуу 2 байршилд	Нийт 6 байршилд	Ширхэг	-	6	1.2	2026 онд	Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл MNS 4585:2007 MNS 5919:2008
2	Төсөлд ашиглагдах машин механизм, дизель станцаас ялгаран гарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Уурхайн бүх төрлийн машин механизмд үзлэг оношилгоо засварыг тогтмол хийж, холбогдох стандартын шаардлагад нийцүүлэх	Уурхайд Ашиглагдаж байгаа бүх машин техник	ширхэг	-	15 авто тээврийн хэрэгсэл	ҮАЗ	2026 он Уурхайн олборлолтоос өмнө	MNS 5013:2003 MNS 5014:2003
3		Уурхайн талбайд ажиллах авто тээврийн хэрэгслийн хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах							
4	Тоосжилт хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт болон хор саармагжуулах бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах;	Уурхайн нийт ажилчид	-	-	Нийт 110 ажилчид	ҮАЗ	2026 он Үйл ажиллагааны турш	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
5	Тэсэлгээнээс үүсэх тоосжилт	Өрөмдлөг тэсэлгээ хийх талбайг урьдчилан чийгшүүлэх	Тэсэлгээ хийх талбайд	-	-	-	ҮАЗ	2026 он тэсэлгээ хийх бүрт	
6	Уурхайн дотоод болон гадаад тээврийн замыг засаж сайжруулах	Ил уурхайн гол амын орчимд болон түүнээс гарч буй замуудад хайрга чулуу дэвсэх, тоос босохоос хамгаалах	Тээвэрлэлтийн зам	км	-	Гадаад тээврийн 3.3 км зам	6.0 ҮАЗ	2026 он	Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолын хавсралт
Гадаргын ба газрын доорх усны нөөц									
1	Ус ашиглалтаас үүсэх сөрөг нөлөөллийг	Ус ашиглах гэрээг байгуулах	Төслийн хүрээнд	-	-	-	Дотоод зардал	2026 он Уурхайн олборлолтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө.	Усны тухай хууль 31.2 зүйл Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
2		Ус ашиглах дүгнэлтийг холбогдох байгууллагаар гаргуулах.	Төслийн хүрээнд	-	-				
3		Тухайн жил уурхайгаас шавхан зайлуулсан усны төлбөрийг гэрээ болон ус ашиглах дүгнэлтэд заасны дагуу төлөх	Төслийн хүрээнд	мян.төг	-	-			
4		Худаг шинээр гарах тохиолдолд холбогдох зөвшөөлийг авч ажиллах/Дорноговь аймгийн БОГ/	Төслийн хүрээнд	-	-	-	Дотоод зардал	2026 он Худаг өрөмдөхөөс өмнө.	
4	Газар доорх усны түвшин ашиглалтын улмаас буурах	Усны эх үүсвэр дээр тоолуур суурилуулах, тоолуур баталгаажуулах	Уурхайн ус шавхан зайлуулах	-	0.05		0.05	2026 он Шавхалт хийж буй хэсэгт	БОНХсайдын 2013-05-16-ны өдрийн А-156 тоот тушаалын Усны тухай хууль MNS OIML R 49-1: 2012
5		Олборлолтын үйл ажиллагаанаас шавхан зайлуулж буй усыг байгаль орчинд ээлтэй технологи	Уурхайн шүүрлийн ус	-			Дотоод зардалд тусгах	2026 он Тухайн ажлыг эхлүүлэх	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
		ашиглан гадаргын усны хуримтлал буй болгох, хөв цөөрөм байгуулах							
3	Хөрсөн бүрхэвч								
1	Хөрс сийрэгжих, үржил шим алдагдаж доройтох	Үржил шимт хөрсний овоолгыг стандартын дагуу хэлбэржүүлж засах,	Шимт хөрсний овоолго	мян.м ³	-			2026 он шимт хөрсний овоолго хийх бүрт	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 5916:2008
3	Шатах тослох материал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Машин механизмын эвдрэл гарсан тохиолдолд засвар үйлчилгээг бетон хучилттай талбайд хийх	Засварын талбайд	-	-	Үйл ажиллагааны зардал		2026 он Засварын газар байгуулах	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
4		Ашиглагдсан тос тосолгооны материал, шатахуун асгарах, гоожих зэрэгт хяналт тавьж ажиллах, асгарсан тохиолдолд саармагжуулах арга хэмжээ авах	Ашиглалтын талбайд	-	0.5	0.5	2026 он Хөрс бохирдсон үед		
5	Амьтаны аймаг								
1	Уурхайн байгууламж руу ан амьтан орж, үхэж хорогдох	АМТЗ-ийн талбайн шаардлагатай хэсгүүдэд хаалт, хашлага барих	АМТЗ-ийн талбайд	ш	1000.0	Хашаалах	5.0	2026 он Үйл ажиллагаа эхлээс өмнө	“Амьтны тухай хууль”
2	Хууль бус ан агнуур ихсэх	Хууль бус хулгайн анг таслан зогсоох, бууруулах үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх зорилгоор зохих шатны	Өргөн сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд	төг	1000.0	Жил бүр 1-ээс доошгүй удаа	1.0	2026 он Үйл ажиллагааны турш	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
		байгууллагуудад техникийн туслалцаа үзүүлж ажиллах;							
3	Уурхайн үйл ажиллагаанаас үүдэн шувуудын тоо толгой буурах	Цахилгаан, холбооны шон дээр шувуу үүр засахаас сэргийлж хамгаалалт, үргээгч байрлуулах;	АМТЗ-ийн талбайд	ш	-	2	2.5	2026 он 3-р улиралд багтаан	
5	Амьтны аймгийн тоо толгойн бүртгэл	Ebird, байгаль хамгаалал, судлаачид, байгалийг танин мэдэх хүсэлтэй хүмүүсийн нэгдэл болсон би байгаль судлаач (I Naturalist), биологийн олон янз байдлын мэдээллийн сан, манай үндэсний судлаачид, байгаль сонирхогчдын хөгжүүлж буй Байгаль апп зэргийг дурдаж	АМТЗ-ийн талбайд болон нөлөөллийн бүсэд	-	-			2026 он Уурхайн дарга болон БО мэргэжилтэн хариуцах	
		Нийт зардал					16.25		

1.6 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Ашиглалтын талбайд нөхөн сэргээлт хийх орон зай болон талбай үүсэхгүй. Бид уурхайн талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх мөн Тэр бум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих зорилгоор ашиглалтын талбай 100 ширхэг мод тарих, шимт хөрсний хамгаалалт хийх зэргийг төлөвлөлөө.

Хүснэгт 9. Нөхөн сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилго	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	
1	Шимт хөрсний овоолгыг ургамалжуулах	2 жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгыг ургамалжуулах	---	-		Дотоод зардал	2026 он /Шимт хөрс хуулах үед/	MNS 5917:2008 MNS 5916:2008
2	Хаалтын арга хэмжээ	Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн арга хэмжээнд жил бүр хуримтлуулах хөрөнгө	Төслийн хэмжээнд		-	Үйл ажиллагааны зардал	2026 он жил бүр	MNS 5915:2008
4	Уурхайн болон ажилчдын хотхоны үйл ажиллагааны улмаас ургамлан бүрхэвч доройтох	Уурхайн тосгоны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил бүр мод тарих Эзэмшил талбайн 10% ийг ногоон байгууламж болгох	Суурин газар ногоон байгууламж байгуулах 500 ширхэг мод	10.0 -	-	10.0	2026 он Хавар болон намрын улиралд	Байгалийн ургамлын тухай MNS 5916-2008 Газрын тухай хуулийн 56.6 заалт
5	Тэр бум мод үндэсний хөдөлгөөн	Орон нутагтай хамтран ажиллах гэрээний 3.2-д заасны дагуу Өргөн сумын ногоон байгууламжийн талбайд хайлаас, шар хуайс модны суулгац тарих					2026 он хавар болон намрын улиралд	
Нийт						10.0		

1.7 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 10. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
1	Дүйцүүлэн хамгааллын ажил хийх талбайг орон нутгийн удирдлагатай тохиролцон сонгох	Орон нутгийн удирдлагаас санал авах	Төсөл хэрэгжих талбайн ойр орчимд эвдрэлд өртөн нөхөн сэргээгдээгүй газрыг сонгох	Орон нутгийн саналын дагуу	-	-	2026 он	Байгаль орчны үнэлгээний тухай хууль
2	Уурхайн шүүрлийн усыг ашиглан нутгийн иргэд, биологийн олон янз байдлын амьдрах орчныг сайжруулах зорилгоор хөв, цөөрөм байгуулах	Хөв цөөрөм байгуулах газрын байршлыг сонгох	Хөв цөөрөм байгуулах	-	-	10.0	2026 он	Усны тухай хууль
3	Мэргэжлийн байгууллагаар хөв цөөрөм байгуулах зураг төслийг хийлгэх			-	-		2026 он	
4	Амьтны амьдрах орчин г сайжруулах	Төмөр замын стандарт, хориг хашааны асуудал оруулах, амьтны мониторинг хийх ажил төлөвлөх	Өргөн сумын хүрээнд	-	-	10.0	2026 он	MNS 7042:2024
	Нийт					20.0		

1.8 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул 2026 оны БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

1.9 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уг төслийн БОНБНУ-ний хээрийн хэмжилт судалгааны үеэр АМТЗ-ийн талбайд нүдэнд ил харагдах түүх соёлын дурсгалт зүйлс ажиглагдаагүй байна. Гэвч бид “Түүх соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийг сахин биелүүлэх үүднээс хэрэв уурхайлалт болон

уурхайн бэлтгэл шатны барилга байгууламж, зам талбайн ажлыг хийж байх үед газрын гүнээс түүх соёлын дурсгалт зүйл гарсан тохиолдолд нэн даруй газар шорооны ажлыг зогсоон төрийн захиргааны төв байгууллагуудад нь мэдэгдэхээр төлөвлөн ажиллах болно.

Хүснэгт 11. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

№	Нөлөөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Уурхайн орчим байж болзошгүй түүх соёлын өвүүд	Шаардлагатай тохиолдолд авран хамгаалах арга хэмжээ зохион байгуулах	Судалгаагаар түүх соёлын биет өв илэрвэл тухайн олдворын хүрээнд	-	Үйл ажиллагааны зардлаас		2026 он	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

1.10 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн 2026 онд хэрэглэгдэх ТБ болон тэсэлгээний хэрэгслийн хэмжээг дараах байдлаар төлөвлөсөн болно. Тэсэлгээний ажлыг Талст бластинг консалтинг ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлнэ. Үүнд:

- ✓ Анфо – 233.494 тн
- ✓ Эмульс – 233.494 тн
- ✓ Шашки – 5200 тн
- ✓ Нонель – 25400 ш

Хүснэгт 12. Осол эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргээх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний, цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, сая.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
Хөдөлмөр хамгаалалал								
1.1	Төслөөс гэнэтийн аваар осол хөдөлмөр	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Нийт ажилчид	110 хүн		ХАБЭА зардалд тусгах	2026 он	

1.2	хамгааллын зөрчил илрэх	Ажил эхлэхээс өмнө хөдөлмөр хамгааллын заавар зөвлөгөөг өдөр бүр өгч байх	Нийт ажилчид	110 хүн		Үйл ажиллагааны зардал	2026 он	
Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх								
2.1	Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс галын аюул гарах Аянга цахилгаан, хэт халалт, хээрийн түймэр, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр галын аюул гарах	Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалыг заасан самбар, галын аюул гарах болзошгүй газруудад зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах, түүний бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах.	Уурхайн тосгон Тэсрэх материалын агуулах ШТС	-	2.45	2.45	2026 он	MNS5078-2001, MNS 5390:2004,
Байгалийн аюул гамшиг								
3.1	Байгалийн гамшиг, аюул ослоос үүсэх эрсдэлүүд	Байгалийн аюул гамшиг, аваар осол, гал түймрийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Нийт ажилчидад	Жилд 1 удаа	1.5	1.5	2026 он	Гамшгаас хамгаалах тухай хууль,
Тэсрэх материалын агуулах								
4.1	Тэсэлгээний ажил болон тэсрэх материалын агуулахтай холбоотой сөрөг нөлөөлөл	Уурхайн тэсэлгээний ажлыг явуулахдаа тэсрэх материалтай харьцах, тэсрэх бодис тээвэрлэх, хадгалах, хураах, устгах ажиллагаанд мөрдөж ажиллах	Тэсрэх материалын агуулах болон тэсэлгээ хийх бүрт	-	-	Талст бластинг консалтинг ХХК хариуцан гүйцэтгэнэ.	2026 он	“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”,
4.2		Тэсэлгээний ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх. Гэрээ байгуулах	Тэсэлгээний ажил хийх бүрт	-	-		2026 он	
		Нийт				3.95		

1.11 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 13. Хог хаягдлын сөрөг нөлөөллийг арилгах бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт	
1	2	3	4	5	6	7	8	9		
Ахуйн хог хаягдал										
1	Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах	Уурхайн талбай болон тосгонд стандартын шаардлага хангасан, ангилан ялгах тэмдэглэгээ бүхий хогийн сав байршуулах	Уурхайн тосгонд Уурхайн талбай	ширхэг	500.0	2 байршилд	1.0	2026	Хог хаягдлын тухай хууль	
2		Хог хаягдлын түр хадгалах цэгийг тохижуулах, хашаажуулах	Уурхайн хог хаягдлын цэг	-	500.0	-	0.5	2026 он	Хог хаягдлын тухай хууль	
3		Уурхайн талбайд байгуулсан хог хаягдал түр хадгалах цэгээс Өргөн сумын төв хогийн цэгрүү хог хаягдлыг тээвэрлэх.	Төслийн хүрээнд	-	-	-	1.0	2026 Гэрээний дагуу зөөвөрлөх	Хог хаягдлын тухай хууль	
4		Уурхайн бие засах газар болон хог хаягдлын цэгүүдэд ариутгал халдваргүйжилд хийх	Уурхайн бие засах шазар хаягдлын цэг			1000.0	2-3 цэгт	1.0	2026 он дулааны улиралд	
5		Хийсч тархсан болон үүссэн хог хаягдлыг тогтмол цэвэрлэж хэвших	Ашиглалтын талбай болон түүний ойр орчимд			-	-	ҮАЗ	2026 Улиралд нэг удаа	
Аюултай хог хаягдал										

1	Тээврийн хэрэгслээс гарах аюултай хог хаягдал	Ашиглагдсан тос, тосолгооны материал, аккумуляторыг тусгай цэг гарган хуримтлуулах	Засварын газарт	-	-	-	-	2026 он	
2	Химийн бодисын сав баглаа боодол	Үйл ажиллагааны явцад гарсан аюултай хог хаягдлыг ангилан ялгах, хадгалах, устгах, зайлуулах	Тэсрэх материал болон баяжуулах үйлдвэрт ашигласан химийн бодисын сав баглаа боодол			Үйл ажиллагааны зардал /Аюултай хог хаягдлыг хадгалах, устгах, тээвэрлэх эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээлэн ажиллах/		2026 он	Хог хаягдлыг тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017-05-12
		Нийт					3.5		

1.12 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт орших Өргөний хайлуур жоншны бүлэг ордын “9-р бүсэд орших хүдрийн биет”-ийг ил уурхайн аргаар ашиглах төслийг хэрэгжүүлэхэд тухайн орон нутгийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, төсөл хэрэгжиж буй орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулав.


Дорноговь аймгийн Цаг уур орчны шинжилгээний газрын Байгаль орчны шинжилгээний төв лабораторитой хамтран ажиллах.

Хүснэгт 14. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
Агаарын чанар								
1.1	Хүхэрлэг хий (SO ₂) Азотын давхар исэл (NO ₂) Нийт тоосонцор	Тэсрэх материалын агуулах Карьер	5-р сард 10 сард	2		500.0	Дорноговь аймгийн ЦУОШГ-ын Байгаль орчны шинжилгээний төв	MNS5061:2001 MNS3113:1981 MNS0017.2.5. 12:8988

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
		Тээврийн зам дагуу					лабораторитой гэрээ байгуулах	
Хөрсөн бүрхэвч								
2.1	Ялзмаг, урвалын орчин (рН), давсжилт, карбонат (CaCO ₃), хөдөлгөөнт кали (K ₂ O), хөдөлгөөнт фосфор (P ₂ O ₅), Шингээгдсэн сууриуд Ca, Mg Хөрсөнд агуулагдах хүнд металл	Шимт хөрсний овоолго Тэсрэх материалын агуулах Карьер	5-р сард 10 сард	2		500.0	Дорноговь аймгийн ЦУОШГ-ын Байгаль орчны шинжилгээний төв лабораторитой гэрээ байгуулах	MNS 2305-94 MNS 3298-1991 MNS 5850:2008
Усан орчин								
	Ca, Mg, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , HCO ₃ , Fe, As, Na, K, Cd, Cu, Pb, Zn, Cr, Ni, Ag, Al, B, Ba, Mg, Mn, Se, Sr, Mo, Co, Be, Sb, Ca-ийн агууламж, амт, үнэр, өнгө, рН, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар,	Шүүрлийн ус, Уурхайн унд-ахуйн усны зориулалттай гүний худаг	5-р сард 10 сард	2		500.0	Дорноговь аймгийн ЦУОШГ-ын Байгаль орчны шинжилгээний төв лабораторитой гэрээ байгуулах	MNS0900:1992 MNS3935:1986 MNS3936:1986 MNS4432:1997 MNS3934:1986 MNS5667-2:2001 MNS4867:1999
Эрүүл мэндийн хяналт								
	Ажилчдын эрүүл мэнд	Нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Жилд нэг удаа	1		ҮАЗ	Эрүүлмэндийн төвтэй хамтран ажиллах	
1 жилд						1500.0		

Зураг 2. ОХШХ-ийн дээж авах цэгийн байршил



1.13 ТУХАЙН ЖИЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв сая.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2020-2024 он				
			Сар 1.2.3.	Сар 4.5.6.7,8	Сар 9.10.11		
1	2	3	4	5	6	7	
1	Байгаль орчны асуудлыг удирдлагын түвшний ажилтанд хариуцуулж, хяналт тавин ажиллах;	ҮАЗ	х	х	х	Захирал	
2	Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх; Гарсан дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;/2 жил тутамд/	Гэрээний үндсэн дээр		2026 он	х	Уурхайн дарга, БО ажилтан, Менежер	
3	Байгаль орчин нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө байршуулах	Жил бүрийн төлөвлөлтийн дагуу			Жил бүр	Захирал	
4	Ажилтнуудад байгаль орчны сургалтуудыг ажлын байранд нь зохион байгуулж,	1.0		Жил бүр		Уурхайн дарга, БО ажилтан, Менежер	
5	Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба тайлан боловсруулах	ҮАЗ			Жил бүр	Уурхайн дарга, БО ажилтан, Менежер	
6	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг хийлгэх/5 жил тутамд/	Гэрээний үндсэн дээр		х		Уурхайн дарга, БО ажилтан, Менежер	
Нийт		1.0					

1.14 ТУХАЙН ЖИЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.

Хүснэгт 16. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов	Тайлагнах зардал мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Өргөн сумын багийн иргэд	ИНХ-д танилцуулах	Тухайн жилд хийгдсэн ажил	Тухайн оны 4 - р улирал	ҮАЗ	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	Багийн төв
2	Дорноговь аймгийн Байгаль орчны газар	https://eic.mn/envmng/ буюу Байгал орчны мэдээллийн санд оруулах	Тухайн жилд байгаль орчны талаар хийгдсэн ажил нөхөн сэргээсэн ажлын акт болон холбогдох материал	Тухайн оны 11 - р сарын 1 дотор	ҮАЗ	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	-
3	Төрийн захиргааны төв байгууллага	https://eic.mn/envmng/ буюу Байгал орчны мэдээллийн санд оруулах, тамгалуулах		Тухайн оны 12 - р сарын 1 дотор	ҮАЗ	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	Төрийн захиргааны төв байгууллага
	Нийт				ҮАЗ		

**БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ
ЗАРДАЛ**

Хүснэгт 17. 2026 оны БОМТ нийт зардал

№	Мэдээллийн төрөл	Нийт зардал сая.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16.25
2	Нөхөн сэргээлтийн зардал	10.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төсөв	20.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний төсөв	3.95
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв	3.5
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	-
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	1.0
10	Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	1.5
	Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв / Сая төгрөг/	56.2